

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2006 ОНЫ 18 ДУГААР ТОГТООЛООР БАТЛАГДСАН “САЙН ДУРЫН ЕРДИЙН ДААТГАЛЫН ХЭЛБЭР”-ИЙН ТАЙЛБАР

## 1.Ердийн даатгал

### 1.1.Амь нас, эрүүл мэндийн даатгал:

#### 1.1.1.Гэнэтийн ослын (Accident Insurance)

Гэнэтийн ослын улмаас даатгуулагчийн амь нас, эрүүл мэндэд учрах хохирлын нөхөн төлбөрийг олгох нөхцөл бүхий даатгал

#### 1.1.2.Эрүүл мэндийн (арилжааны даатгал) (Health Insurance)

Даатгуулагч өвчний улмаас эмнэлэгт эмчлүүлэхэд гарсан зардлыг даатгах даатгал

#### 1.2.3.Хөдөлмөрийн чадвар түр алдалтын (Disability Insurance)

Даатгуулагч хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдсан тохиолдолд түүнд энэ хугацаанд олгох тэтгэмжийг нөхөн төлөх нөхцөл бүхий даатгал

### 1.2.Эд хөрөнгийн даатгал:

#### 1.2.1.Хөрөнгийн

Сайн дурын ердийн даатгалын хэлбэрийн жагсаалтын 1.2.2–1.2.15-т зааснаас бусад төрлийн эд хөрөнгөд учирч болзошгүй хохирлын эрсдэлийг даатгах даатгал

#### 1.2.2.Байшин барилгын

Үйлдвэрлэлийн ба үйлдвэрлэлийн бус зориулалттай барилга байгууламж, агуулах зоорь, гаражийн барилгад учирч болзошгүй хохирлын эрсдэлийг даатгах даатгал (орон сууцны зориулалттайгаас бусад)

#### 1.2.3.Орон сууцны

Нийтийн болон хувийн орон сууц, хашаа байшин, гэрийг учирч болзошгүй аливаа эрсдэлээс даатгах даатгал

#### 1.2.4.Бараа материалын

Бүх төрлийн бараа материалыг учирч болзошгүй аливаа эрсдэлээс даатгах даатгал (бараа, бэлэн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүн, түүхий эд, туслах материал гэх мэт)

#### 1.2.5.Тоног төхөөрөмжийн

Бүх төрлийн тоног төхөөрөмжийг учирч болзошгүй аливаа эрсдэлээс даатгах даатгал (ашигт малтмал, уул уурхай, газрын тосны тоног төхөөрөмжөөс бусад)

#### 1.2.6.Авто тээврийн хэрэгслийн

Авто тээврийн хэрэгсэлд учирч болзошгүй хохирлын эрсдэлийг даатгах даатгал

#### 1.2.7.Ачааны

Ачаа болон ачааг тээвэрлэхтэй холбогдсон зардлыг аливаа эрсдэлээс даатгах даатгал

#### **1.2.8.Иргэний агаарын хөлгийн**

Иргэний агаарын хөлөг, нисдэг тэрэгний их бие, тэдгээрийн сэлбэг хэрэгсэлд учирч болзошгүй хохирлын эрсдэлийг даатгах даатгал

#### **1.2.9.Газрын тосны**

Газрын тос олборлогч компанийн үйлдвэрлэлийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, олборлосон газрын тосонд учирч болзошгүй хохирлын эрсдэлийг даатгах даатгал

#### **1.2.10.Газрын тосны бүтээгдэхүүний**

Бүх төрлийн шатах, тослох материал, нефть бүтээгдэхүүн, тэдгээрийг хадгалах сав, тоног төхөөрөмж, шахуурга, түгээгүүр, ил далд шугам хоолойд учирч болзошгүй хохирлын эрсдэлийг даатгах даатгал

#### **1.2.11.Ашигт малтмал, уул уурхайн**

Ашигт малтмал олборлох уул уурхайн барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд учирч болзошгүй хохирлын эрсдэлийг даатгах даатгал

#### **1.2.12.Таримлын**

Төмс, хүнсний ногоо, үр тариа, бусад таримлыг аливаа эрсдэлээс даатгах даатгал

#### **1.2.13. Мал амьтдын**

Мал болон гэрийн тэжээвэр амьтдыг аливаа эрсдэлээс даатгах даатгал

#### **1.2.14 Баримт бичгийн**

Баримт бичгийг алдаж үрэгдүүлснээс үүдэн учирч болзошгүй хохирлын зардлыг даатгах даатгал

#### **1.2.15 Илгээмж шуудангийн**

Шуудангаар илгээж буй баримт бичиг, илгээмжид учирч болзошгүй хохирлын эрсдэлийг даатгах даатгал

### **1.3.Хариуцлагын даатгал**

#### **1.3.1.Жолоочийн хариуцлагын**

Авто тээврийн хэрэгсэл өмчлөгч болон эзэмшигч жолоочийн буруугаас болж бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирч болзошгүй хохирлын хариуцлагыг даатгах даатгал

#### **1.3.2.Бүх төрлийн мэргэжлийн хариуцлагын**

Ажил мэргэжлийн санамсаргүй болон болгоомжгүй алдааны улмаас бусдад учирч болзошгүй хохирлын хариуцлагыг даатгах даатгал

#### **1.3.3.Иргэдийн хариуцлагын**

Иргэний санамсаргүй болон болгоомжгүй үйлдлийн улмаас бусдад учирч болзошгүй хохирлын хариуцлагыг даатгах даатгал

#### **1.3.4.Барилга угсралтын хариуцлагын**

Барилга угсралтын ажлын явцад барилгын гүйцэтгэгчийн санамсаргүй болон болгоомжгүй үйлдлийн улмаас бусдад учирч болзошгүй хохирлын хариуцлагыг даатгах даатгал

#### **1.3.5.Орон сууцны хариуцлагын**

Орон сууц өмчлөгч болон эзэмшигчийн санамсаргүй болон болгоомжгүй үйлдлийн улмаас бусад оршин суугчдад учирч болзошгүй хохирлын хариуцлагыг даатгах даатгал

#### **1.3.6.Олон нийтийн өмнө хүлээх хариуцлагын**

Хуулийн этгээдийн санамсаргүй болон болгоомжгүй үйл ажиллагааны улмаас олон нийтийн эрүүл мэнд, нийтийн эзэмшлийн эд хөрөнгөд учирч болзошгүй хохирлын хариуцлагыг даатгах даатгал

#### **1.3.7.Байгууллагын хариуцлагын**

Байгууллагын буруутай үйл ажиллагааны улмаас бусдын эрүүл мэнд, эд хөрөнгөд учирч болзошгүй хохирлын хариуцлагыг даатгах даатгал (энэ жагсаалтын 1.3.6 орохгүй)

#### **1.3.8.Өмчлөгч болон эзэмшигчийн хариуцлагын**

Өмчлөгч болон эзэмшигч өөрийн эд хөрөнгө, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ажиллуулах явцад гаргасан санамсаргүй болон болгоомжгүй үйлдлийн улмаас бусдад учирч болзошгүй хохирлын хариуцлагыг даатгах даатгал (энэ жагсаалтын 1.3.1 орохгүй)

#### **1.3.9.Бүтээгдэхүүн, үйлчилгээний хариуцлагын (экспортлогч, импортлогч, үйлдвэрлэгч)**

Дотоодод үйлдвэрлэсэн, эсхүл импортлосон бүтээгдэхүүн хэрэглэсний улмаас хэрэглэгчдэд учирч болзошгүй хохирлын хариуцлагыг даатгах даатгал

#### **1.3.10.Тээвэрлэгчийн хариуцлагын**

Зорчигч болон ачаа тээвэрлэх явцад тээвэрлэгч этгээдийн гаргасан санамсаргүй болон болгоомжгүй үйл ажиллагааны улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирч болзошгүй хохирлын хариуцлагыг даатгах даатгал (энэ жагсаалтын 1.3.1 ба 1.3.11 орохгүй)

#### **1.3.11.Агаарын хөлгийн их бие, түүнийг өмчлөгч болон эзэмшигчийн хариуцлагын**

Агаарын хөлгийн их биеийг өмчлөгч болон эзэмшигчийн буруутай үйл ажиллагааны улмаас зорчигч болон бусад этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирч болзошгүй хохирлын хариуцлагыг даатгах даатгал

#### **1.3.12.Гэрээний хариуцлагын (Contractual Liability Insurance)**

Аливаа гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас бусдад учирч болзошгүй хохирлын хариуцлагыг даатгах даатгал (энэ жагсаалтын 1.3.13, 1.3.14, 1.3.15-аас бусад нөхцөл орно)

#### **1.3.13.Хуулийн хариуцлагын (Legal Liability Insurance)**

Санамсаргүй болон болгоомжгүйгээр хууль журам зөрчсөний улмаас бусдад учирч болзошгүй хохирлын хариуцлагыг даатгах даатгал

#### **1.3.14. Ажил олгогчийн хариуцлагын (Employers Liability Insurance)**

Ажил олгогч этгээд, түүний ажилтан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа гаргасан санамсаргүй болон болгоомжгүй үйлдлийн улмаас бусдад учирч болзошгүй хохирлын хариуцлагыг даатгах даатгал

#### **1.3.15. Ажиллагсдын хариуцлагын (Employee's Liability Insurance)**

Ажиллагсад ажил үүргээ гүйцэтгэх явцдаа гаргасан санамсаргүй болон болгоомжгүй үйлдлийн улмаас ажил олгогчид, эсхүл гуравдагч этгээдэд учирч болзошгүй хохирлын хариуцлагыг даатгах даатгал

### **1.4. Санхүүгийн даатгал**

#### **1.4.1. Бизнес тасалдлын (Business Interruption Insurance)**

Гэнэтийн таагүй үйл явдал, тухайлбал галын аюул, осол, эсхүл тоног төхөөрөмжийн гэмтэл зэргээс болж бизнесийн үйл ажиллагаа тасалдахад хүрч, үүний улмаас учирч болзошгүй хохирлын эрсдэлийг даатгах даатгал

#### **1.4.2. Зээлийн эрсдэлийн (Credit Insurance)**

Зээлдэгчийн авсан зээл хугацаандаа эргэж төлөгдөхгүй байх эрсдэлээс даатгах даатгал

#### **1.4.3. Хадгаламжийн (Deposit Insurance)**

Банк, санхүүгийн байгууллага дахь хадгаламжийг аливаа эрсдэлээс даатгах даатгал

#### **1.4.4. Бэлэн мөнгө, үнэт цаасны (Money and Security Insurance)**

Бэлэн мөнгө болон үнэт цаас хадгалах, зөөх, тээвэрлэх үед мөнгө, үнэт цаас алдагдаж болзошгүй эрсдэлээс даатгах даатгал

#### **1.4.5. Чин шударгын баталгааны (Fidelity Guarantee Insurance)**

Ажилтны худал хуурмаг үйлдлийн улмаас ажил олгогчид учирч болзошгүй хохирлын эрсдэлийг даатгах даатгал

#### **1.4.6. Гүйцэтгэлийн баталгааны (Performance Guarantee Insurance)**

Аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авсан хэрэглэгчээс хийх төлбөр хийгдээгүйн улмаас бусдад учирч болзошгүй хохирлын эрсдэлийг даатгах даатгал (1.4.2 орохгүй)

### **1.5. Давхар даатгал**

#### **1.5.1. Гадагш өгөх давхар даатгал (Outward Re-insurance)**

#### **1.5.2. Гаднаас авах давхар даатгал (Inward Re-insurance)**

**ДААТГАЛЫН ГАЗАР**